

## II. Монголын дундат зууны түүхийн асуудлууд

### УЛСЫН НЭРИЙН ТУХАЙ (XIV-XVII зуун)

Д.Энхцэцэг

Монгол Улсын Их Сургууль, Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль, Түүхийн тэнхим.

**Өгүүллийн тоөч утга:** Манай Монгол Улсын эртнээс уламжилж ирсэн, "сүр оруулж гоёж чимсэн, цагийн аяст зохицуулан элдэв тодотгол хийгээгүй" эгэл мөртлээ эрхэмсэг хүндтэй, түүхийн нугачаанд орхигдон маргагдаагүй, дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн нэр болох "Монгол Улс" хэмээх нэр XIV-XVII зууны монголчуудын улсын нэр байсан.

**Түлхүүр үг:** "Монгол Улс", "Юаний хойчис", "Мин Улсын үеийн монголчууд", "Умард Юань", "Бэйлуу", "Дөчин түмэн Монгол улс", "Дөчин дөрвөн хоёрын Монгол улс".

Эрт үеэс эдүгээ хүртэл төр улсын түүхийн явцад аливаа улс орон бүр тунхаглан зарласан өөр өөрийн нэртэй байсан. Тэр нь:

- Тухайн улс түмний онцлогийг илэрхийлж, тусгаар тогтолыг зарлаж, хүндэтгэл баархал, бэлгэдлийг төлөөлсөн нэр байх,
- Тухайн ард түмнийг хөрш зэргэлдээ улс орон бусдаас ялгарах содон шинжээр нь онцгойлон нэрлэсэн, эсвэл басамжлан доромжлох зэргээр хэрхэн нэрлэж ирснээс үүдэлтэй билээ.

Олон зууны тэртээх монголчуудын улсын нэрийн талаар "ямар нэртэй" байсан нь их л бүрхэг агаад эрдэмтэд судлаачид судлан бүхий үе, улсын онцлогийг харгалзан, "нэр өгөх" явдал түгээмэл үзэгдэл байжээ. XIII, XIV зууны Монгол Улсыг "Хөх Монгол", "Нүүх Монгол", "Их Монгол улс", "Тулгар Монгол улс", "Нэгдсэн Монгол улс", "Хаант Монгол улс", "Монголын Юань улс" зэргээр нэрлэж, найман зууны тэртээгээс монголчуудын оршин буйг илтгэж, сүр хүчийг дэлхий дахинаа тунхаглаж байлаа.

XIV зууны II хагаст Хятад дахь монголчуудын ноёрхол төгсгөл болж, "Юань Улс" мөхсөний дараа эрх мэдлээ булаацалдсан хаад ноёд төр барьж, улс төрийн бутрал эхлэн 300 жил үргэлжилжээ. Монголын нэр сүр доройтон төрийн төвлөрсөн бодлого, засаг цааз нэг суларч, нэг бэхжиж байв. Энэ үед улсын нэрийдлийн хувьд "чухам юу гэж нэрлэж байв?" гэдэг нь нилээд сонирхолтой.

XIV зууны II хагасаас XVII, XVIII зуун хүртэлх Монгол, Хятад, Төвд болон тод үсгийн сурвалжуудын мэдээ, судлаачид эрдэмтдийн бүтээлүүдэд энэ асуудал хэрхэн тусгагдсаныг нягталбал янз бүрээр томъёолж иржээ. Үүнд: "Мин улсын үеийн Монгол", "Юань улс мөхснэй дараах Монгол", "Юаний үлдэгдэл", "Юаний хойчис", "Хуучин Юаний хүчин доройтсон ба Мин улсаас ван өргөмжлөл зассан үе", "Самуурлын үе", "Татар, Ойрад, Урайнхайн аймаг", "Монголын хаант улс", "Бэйлуу", "Нан Вэй", "Дөчин түмэн их Монгол улс", "Дөчин түмэн Монгол улс", "Арван түмэн Монгол", "Зургаан түмэн Монгол улс", "Дөчин дөрвөн хоёрын Монгол улс", "Монгол Ойрадын улс" гэх зэргээр бичиж байжээ.

**Нэгдүгээрт:** Хятадын Мин улсын түүх, сурвалж бичигт анх тэмдэглэгдэн улмаар өрнө дорнын судлаачдын зохиол бүтээлд өгүүлэгдэн буй үеийг "Монгол Улс тусгаар улс болохыг шууд үгүйсгэж, Хятадын харьяат байсан" гэсэн санаа өнө удаан хадгалагдаж ирсэн. Тэд, "Мин Улс бол нэгдэлтэй (нэгдмэл) улс. Монгол бол Мин улсын төвийн эрхийг (төв засаг захиргааны) харьян дахь нэг газар орныг хэсэглэн эзэлсэн хүчин болно."<sup>1</sup> гэж үзэх болохоор "Мин улсын үе дэх Монгол", "Юань улс мөхсөний дараах Монгол"<sup>65</sup> гэж нэрлэх болжээ. Эдгээр нь

<sup>1</sup> Дай Хуни... "Умард Юаны түүх" Хайлаар, 1991. т.3

хэдийгээр "албан бус" хэллэг боловч БНХАУ, ӨМӨЗО ба бусад эрнэ эрдэмтдийн бүтээлүүдэд, тухайлбал Буянхүү<sup>2</sup>, Даарийжав<sup>3</sup>, Асралт<sup>4</sup>, Вада Сэй<sup>5</sup>, Покотилов.Д<sup>7</sup>, Монсеев В.А<sup>8</sup>, Serryus.Н<sup>9</sup>, Хагираава Жеппэй<sup>10</sup> нарын зохиол бүтээлүүдэд зөвхөн нэрийн хувьд Мин Улсын үеийн Монгол гэж тусгаар улс бус мэтээр авч үзсэн нь харагдаж байна. Мин, Чин улсын түүх бичлэгт "Юаний хойчис", "Юаний үлдэгдэл", "Хуучин Юаний хүчин доройтсон ба Мин улсаас Ван өргөмжлөн засссан үе" гэж Монгол улсын нэрийг төлөөлүүлэн бичих нь түгээмэл үзэгдэл байжээ. Үүнд: Юн-ло (1408-1411) хааны үед шинээр засаж бичсэн "Мин Улсын Тайзу хааны магад хуульд": "Үлдэгдэл Юань" (故元) "Юаний хойчис" (故元) гэх мэтээр тэмдэглэсэн байна. Мөн, Тогтохын ойчсэн "Өвөр Монголын хөгжлийн тойм" номын дэд дэвтэрт "Самуурлын үе (-ийн Монгол)"<sup>11</sup> хэмээх нэрийг хэрэглэсэн байх боловч одоо бараг хэрэглэгдэхгүй байна. Дээрх бүх нэрийдэл нь Монгол улсыг тусгаар улс бус гэсэн санааг илтгэж байна.

Хоёрдугаарт: "Хойд Юань Улс", "Умард Юань улс", "Ар Юань" хэмээх нэрийн талаар авч үзвэл XIV-XVII зууны Монгол улсыг Тогоонтөмөр (1332-1370) хааны үед "Ар Юань" гэж нэрлэх болсон хэмээн зарим судлаачид бичдэг. Өвөр монголын түүхч Дай Хуни, Буян нар "Умард Юаний түүх бол 1368 он (д) Юань Улсын эцсийн хаан Тогоонтөмөр нийслэл Дайду (Бээжин)-гаас ухран гарч Умард монгол орондоо буцснаас 1634 он даруй Чингис хааны алтан ургийн үе залгамжилсан эцсийн хаан Лигдэний цэрэг дарагдан, Хөх нуурт нас барсан хүртэл нийт 267 жилийн хөгжлийг өнгөрүүлсэн байна."<sup>12</sup> гэж XIV зууны II хагсаас XVII зууны эхэн хагас хүртлэх монголчуудын түүхийн бүхий л үеийг "Умард Юань Улс" хэмээн нэрийддэг тухай бичжээ. "Умард Юань Улс" хэмээх томъёолол нь өмнөх зүйлд дурдсан олон нэртэй харьцуулбал Мин, Монгол улс хоёул тусгаар улс гэсэн санааг заах мэт боловч нөгөө талаар "Умард Юань" нь Хятад Монголыг нэгтгэсэн "Их Юань улс"-ын үргэлжлэл гэж, дээрх санаагаа бүрхэгдүүлж байна."Умард Юань" гэсэн нэр анх солонгосын Ли овогтны "Төрийн магад хууль"-ын "хуулийн түүхийн" тэмдэглэлд бичигджээ. Тус хуулийн түүхийн 133-р ботийн "Шин-Ну-гийн намтарт": "Шин-Ну-гийн угсааны 3-р он (1377)<sup>13</sup> оны 2 сараас эхлэн Умард Юаний "Сидван Гован"-ы оны цолыг эхлэн (в)"<sup>14</sup> гэжээ. Чин Улсын үеийн бичигт "Шинди хааны тайзу Аюшридара Хун-Нугийн 3-р он цагаан нохой жил (1370 он) Инчанд суурин залаад оны цолоо "Сидван Гован" гэж өөрчлөн (улсаа) "Умард Юань" гэж нэрийдэв."<sup>15</sup> гэх зэрэг баримтаас үзвэл Билэгт хааны үеэс Умард Юань нь улсын нэр болжээ. Манай монгол сурвалжид үүний **адил** зүйлс тэмдэглэгдэн үлдجээ. Тухайлбал: Раашпунцаг "Тэндээс Шун-Ди хааны . . . хун тайж Аюшридара 34 насандаа . . . Инчанфу хотноо хааны ор тавцан дор залгамжилж, Хойд Юань улс хэмээн нэрийдээд Хотол монгол улсаа эзлэн сууваа. . ."<sup>16</sup>, Дармаагүүш "Билэгт хаанаас Лигдэн хутагт хүртэл удамд дахь Юань улсыг эзэлсэн 20 хааны төр шашныг ямар мэт тэтгэсэн гутгаар дэвтэр оршивай"<sup>17</sup> зэргээс үзвэл "Умард Юань", "Хойд Юань" улс гэж нэрлэсэн нь адил боловч

<sup>2</sup> Буянхүү "Миндай Мэнгу ши лунь" (Мингийн үеийн монголын түүхийн тухай) Тайбэ., 1998

<sup>3</sup> Даарийжав "Мин Улсын үеийн өмнөх хэсгийн монголчуудын түүхийн судалгаа" Хөх хот., 1998

<sup>4</sup> Асралт "Мин улсын үеийн Монгол ба Дундад улсын худалдааны харилцаа" Бээжи., 1964

<sup>5</sup> Вада Сей "Мин улсын монголын түүхийн тухай өгүүллүүдийн эмхэтгэл" Бээжин., 1984

<sup>6</sup> Вада Сей "Мин улсын монголын түүхийн тухай өгүүллүүдийн эмхэтгэл" дээд доод дэвтэрээд Бээжин., 1998

<sup>7</sup> Покотилов.Д "История восточных Монголов в период династии Мин" (1368-1634, по китайским источникам) Спб., 1893

<sup>8</sup> Монсеев.В "Мин дай мамо сире"

<sup>9</sup> Serius H. "Sino-Mongolian Relations during Ming..." (1400-1600), Brussels, 1967.

<sup>10</sup> Хагираава Желлэй "Мин дай маако ши кенкю" (Мингийн үеийн монголын түүхийн судалгаа) Киото., 1980

<sup>11</sup> Дай Хуни . . . "Умард Юаны түүх" Хайлаар, 1991 т.3

<sup>12</sup> Мөн тэнд т. 4

<sup>13</sup> Аюшридара Билэгт хаан сууж байв.

<sup>14</sup> Дай Хуни . . . "Умард Юаний түүх" Хайлаан., 1991 т.8

<sup>15</sup> Мөн тэнд т.9

<sup>16</sup> Раашпунцаг "Болор эрхи" Хөх хот., 2000 т. 337

<sup>17</sup> Дармагүүш "Алтан хурдэн мянган хигээст бичиг" Хөх хот., 1987 т 109-128

хамрах он цагийн хүрээний хувьд харилцан өөр саналыг агуулж байна. Дай Хуни, Буян, Раашпунцаг, Дармаагүүш нар "Умард Юань" улс нь XIV зууны II хагасаас XVII зууны дунд үе хүртэл манай улсын нэр байсан гэж үзжээ. Тэгвэл, монгол түүхийн бусад сурвалж, судлаачдын бүтээлүүдээс нягталбал энэ нэр зөвхөн хэсэг хугацаанд бүр тодруулбал, Аюушридара, Төгстөмөр (Усгал) хаадын үе 1370-1389 он хүртэл ("20 орчим жил")<sup>18</sup> зурvas үеийг зааж байсан бололтой. Аюушридара, Төгстөмөр хаадын эзэмшилд Монгол Улсын үндсэн нутаг төдийгүй, өмнөд хятадын зарим нэг муж, хойд хятадын үлэмж хэсэг нь харьяалагдаж байв. Тэдний Их Юанийн ноёрхлыг дахин сэргээхийн төлөө тэмцэл амжилтгүй болж, түүнээс хойш түүх сударт Умард Юань гэх нэр хэрэглэгдэхээс больжээ. Манай улсын эрдэмтэд ч энэ санааг баримталж байв. Харин Өвөр Монголын судлаачдын хувьд 1990-ээд оноос хойш бичигдсэн зохиолуудад тухайлбал: Дай Хуни, Буян<sup>19</sup> Дэмбээ (Дамба)<sup>20</sup> Монгол үндэсний нэвтэрхий түүх<sup>21</sup>, Даарийжавын сүүлийн үед бичсэн өгүүлэл зэрэгт "Умард Юань" хэмээх нэрийг ихэвчлэн хэрэглэх болжээ.

**Гуравдугаарт:** Мин улсын түүх сударт Монгол улсыг тус улсын бүрэлдэхүүний аймаг, хавсралаа улс бус харин "харь улс" болохыг, Монгол Мин улс зэрэгцэн оршиж байсныг илэрхийлсэн нэрийдэл бас байх юм. Их Юань улсыг сэргээж Хятад дахь Монголын ноёрхолыг дахин тогтоох оролдлогоо биелүүлж чадаагүй ч Аюушридара Төгстөмөр хаадыг залгамжлагчдын үеийг Мин Улсын түүх сударт нэгэн том улс гэж нэрлэхээс аль болох зайлсхийн "харь аймаг", "нүүдэлчин аймаг", "Бэйлу", "Татар, Ойрад, Урайнхай аймаг", "Нан Вэй" гэж нэрлэж байжээ. Мин улсын түүхэнд тухайн үеийн монгол улсыг Татар ( ) хэмээн нэрлэж байжээ. Мин улсын дунд ба сүүл үеийн сурвалж бичигт монголчуудыг ихэвчлэн Бэйлу ( 北虏 ) буюу "Умардын дээрэм" гэж нэрлэсэн байна. Үүнд: Мин Ээ, Шан Рэн<sup>22</sup> Жоо Ши Чун<sup>23</sup> Е.Сэнгао<sup>24</sup>, Хоу Жэнь Чжи<sup>25</sup> Чжэ Сяо<sup>26</sup> зэргийг зурдаж болно. Энэхүү "Нан Вье" ( 南倭 ) (Нан Вэй) "Пандгар япон" гэсэн үг буюу Хятадын өмнөд хэсгийг түүвээдэг япончуудтай монгол аймгуудыг адилтган "Бэйлу" буюу "умардын дээрэм" ( ) гэж муушаан нэрлэж байсны гэрч бололтой. Эдгээр нэрийдэл нь хэдийгээр монголчуудыг басамжилсан доромжилсон утга бүхий боловч нөгөө талаар хятад дахь Юань улсын ноёрхол улирч, Тогоонтөмөр түүний залгамжлагчид угуул нутаг улсаа эзэмшин сууж, хасбуу тамга үе улиран атгаж, хаадын эрхэмсэг цол өргөмжлөгдөн, бие даан гадаад дотоод бодлогоо үргэлжлүүлэн явуулж, Мин улстай энэ зэрэгцэн оршин тогтнож байсны баталгаа юм. Энэ бүхнээс үзвэл хятадын түүх судар болон судлаачдын бүтээлүүдэд Монголыг олон янзаар нэрлэж ирсэн нь улсын нэрийдлийн хувьд төдийлөн тохиромжтой бус болох нь түүхийн судалгааны явцад тодорхой харагдаж байна.

**Дөрөвдүгээрт:** Харь хэлний хятад, солонгос сурвалжид төдийгүй монгол сурвалж бичгүүдэд тухайн үеийн улсын нэр хэрхэн тэмдэглэгдэн улирч ирсэн, судлаачид энэ талаар ямар саналтай байдгийг тоймлон тэмдэглэвэл: "Дөчин түмэн их Монгол улс, Дөчин түмэн Монгол улс, Монгол улс, Арван түмэн Монгол улс, Зургаан түмэн Монгол улс" Дөчин дөрвөн хоёрын Монгол улс, Монгол Ойрадын улс" гэх зэргээр бичсэн байна. Юуны өмнө "Дөчин Түмэн их Монгол

<sup>18</sup> Санждорж.М "Монгол төрийн түүхээс" XIII-XIX зуун УБ., 1998 т. 15

<sup>19</sup> Дай Хуни, Буян дээр дурьдсан зохиол

<sup>20</sup> Дамба "Умард өнийн мандал буурал" Хөх хот., 1998

<sup>21</sup> "Монгол үндэсний нэвтэрхий түүх" думдад дэвтэр. Бээжин., 1995

<sup>22</sup> Мин Ээ, Шан Рэн "Ий Юи бичиг"

<sup>23</sup> Жоо Ши Чун "Бэй Лу Жи Льюэз"

<sup>24</sup> Е.Сэнгао "Хөд бүдүүлгүүдийн судалгаа"

<sup>25</sup> Хоу Жэнь Чжи "Хуан Мин Бэй Лу Као" (Мин улсын хойд дээрэмчдийн судалгаа)

<sup>26</sup> Чжэ Сяо "Хуан Мин Бэй Лу"

улс", "Дөчин түмэн Монгол улс гэх нэрийг судалсан түүхч Алтан-Оргилын дурдсанаар "Монголын нууц товчоо", Судрын чуулган" зэрэг сурвалжид дээрх нэр огт байхгүй бололтой. Харин Юань улсын шаштирт: "Чингис хаан . . . Дөчин улсыг сөнөөсөн гэх ба Джувейнийн Ертөнцийг байлдан дагуулагчийн түүхэнд 1241 онд Бат хаан европд цөмрен орохдоо . . . (Дөчин түмний) тухай дурьдсан цөөн баримт<sup>27</sup> тэмдэглэжээ. Улмаар XVII зуунаас хойшх сурвалж бичгүүдэд "Дөчин түмэн монгол улс нэрийг олонтоо дурьдаж эрдэмтэд олон янзаар тайлбарлах болжээ. "Түмэн" нь түмэн цэрэг гаргах зохион байгуулалттай холбоотой бөгөөд бүр Хүннү улсын үеэс цэргээ Аравт, Зуут, Мянгат, Түмтээр зохион байгуулдаг заншилаас үүдэн Сүмбэ, Нирун, Түрэг, Кидан, Их монгол улсын үед уламжлан хэрэглэсээр ирсэн нүүдэлчдийн цэрэг засаг захиргааны дээд шатны нэгж байжээ. XVII-XX зууны түүхийн сурвалж бичгүүдэд "Түмэн" нь аймаг, хошуу, төр улс, ард иргэн зэрэг нэртэй харилцан хутгалдаж хэрэглэгдэх болсон тул "Дөчин түмэн монгол улс", "Дөчин түмэн хүн амтай улс", "Дөчин түмэн өрх амтай улс", "Дөчин түмэн аймаг бүхий улс", "Дөчин хошуу бүхий улс", "Дөчин түмнээс бүрэлдсэн улс" юм уу гэдэг нь ихээхэн бүрхэг байна. Иймд, эрт цагт Дөчин түмэн бүхий байсныг хожим улс орон доройтохын хамт хүчирхэг үеийн бэлэгдэл болгон уг нэрийг хэрэглэсэн ч байж болох юм. Сурвалж бичгийн мэдээг үндэслэвэл, тухайн үеийн түүхид энэ нэрийг ихэвчлэн XIII-XIV зууны үе тухайлбал Чингис эзний үеийн түүхийг нэхэн өгүүлэхэд дурдсан байна. Үүнд: "Чингис хааны байгуулсан Дөчин түмэн Би Та улс"<sup>28</sup>, "Дөч илүү улсыг эрхэндээ хурааж Их Монгол улс хэмээн нэрийдэв"<sup>29</sup>. "Эртний Дөчин түмэн Монгол улс..."<sup>30</sup> гэж нэрлэв. Энэ мэт олон иргэн улс Дөчин түмэн монгол, Хорин түмэн харлаг, 13 түмэн түмээр . . . цөм эрх дор орон аталь"<sup>31</sup> гэх зэргээр XIII-XIV зууны үеийн түүхнээ уг нэрийг хамаатуулан бичсэн байна. Мөн хожуу үеийн хаад тухайлбал, Лигдэн хаан 1619 онд Зүрчидийн Нурухайд элч илгээн өөрийгөө Дөчин түмэн олныг захирсан Монгол улсын эзэн . . .<sup>32</sup> гэж нэрлэж байснаас үзвэл Их Монгол улсын нэрийг ашиглан бусад улстай харилцахад хэрэглэж байжээ. Иймээс "Дөчин түмэн монгол улс хэмээх нь XIV-XVII зууны улсын албан ёсны нэрийдэл хараахан бус харин уг нэрийг аливаа сайн сайхан, хүчирхэгжилт, бүрэн бүтэн байдал, эрх сүртэйн бэлэгдэл болгон хэрэглэж байжээ гэж үзүүштэй. "Арван түмэн монгол улс", "Зургаан түмэн Монгол улс" гэх нь өмнө дурдсан "Дөчин түмэн Монгол" улсын нэрнээс улбаалан үлдсэн юм. Монгол түүхийн сурвалжид: "Тогоонтөмөр хаан Дөчин түмэн монголынхoo Гучин түмнийг нь орхин, арван түмнийг авч гараад Элбэг Нигүүлсэгч хааны үеэс Арван түмэн Монгол нь Зургаан түмэн Монгол, Дөрвөн түмэн Ойрад болж салсан"<sup>33</sup>. "Дөчин түмэн монголоос арван түмэн нь гарч гучин түмэн нь хаагдан хоцров".<sup>34</sup> "Зургаан түмэн монгол, Зургаан түг түмэн монгол"<sup>35</sup>, "Зургаан түмэн монгол улсаа эзлээд"<sup>36</sup> "Тогоотөмөр урьд хожид . . . гарсан Зургаан түмэн монгол улсаа цуглуулж монголын хаан болов"<sup>37</sup> зэргээр олонтоо тэмдэглэжээ. Энэ бүхнээс үзвэл "Арван түмэн монгол", "Зургаан түмэн монгол" нь улсын нэр бус

- (Улсыг бүрэлдүүлж буй хэсгийг илэрхийлж буй нэр

<sup>27</sup> Алтан-Оргил "Дөчин түмэн монгол улс хэмээх нэрийдлийн судлал" Хөх хот

<sup>28</sup> Саган Сэцэн "Эрдэний товч" Хөх хот., 1994 т.15-16., т. 143-146

<sup>29</sup> Гомбожав "Гангын урсгал" . . . УБ., 1992 т. 6

<sup>30</sup> Ломи "Монгол боржигид овгийн түүх" Хөх хот., 1989 т. 328

<sup>31</sup> Жамбадорж "Болор толь" Хөх хот., 1994 т. 415

<sup>32</sup> Дайчин улсын тулгар төр нээсэн бодлого" 7-р дэвтэр (XIV-XVII зууны монголын гадаад харилцаа) УБ., 1997 т. 47

<sup>33</sup> "Хаадын үндэсний хураангуй алтан товч" Хөх хот., 2000 т. 55

<sup>34</sup> Саган Сэцэн "Эрдэний товч"... т. 273

<sup>35</sup> Гомбожав "Гангын урсгал" . . . т. 23

<sup>36</sup> Ломи . . . Хөх хот., 1973 т. 288, 308

<sup>37</sup> Жамбадорж "Болор толь" Хөх хот., 1994 т.444

- Их улс хэрхэн доройтсон бутран сарнисан болохыг илэрхийлж буй хэллэг гэж ойлгож болох юм.

"Дөчин дөрвөн хоёрын монгол улс", "Монгол Ойрадын улс" хэмээх нэрийн талаар манай сурвалж бичгүүд, судалгааны ном зохиолд ихэвчлэн Тогоонтайшийн үе, Эсэнтайш монголыг нэгтгэн захирсан үе буюу Ойрадын манлайллын дор нийт монголчууд нэгдсэн тухай дурьдахдаа хэрэглэсэн байх юм. Тухайлбал, Саган Сэцэний түүхэнд "Тогоон: Эдүгээ хамаг монгол улс миний боловоо. . . Хэрэв Дөчин дөрвөн хоёр хагацан дайжваас. . . , тэндээс Дөчин дөрвөн хоёрыг цуглуулж, Дөчин дөрвөн хоёр нэгэн амой, Эсэнчи Дөчин дөрвөн хоёрын хаан болов. Дөчин дөрвөн хоёрын төрийг барьсанд"<sup>38</sup>, "Торгууд хааны түүж" хэмээх тод үсгийн дурсгал бичигт: луу жил (1640) . . . Дөчин дөрвөн хоёр хуучин эвдрэлээ уураад (болиод) санаа нэгдэж их цааз тогтоогоод . . . <sup>39</sup> гэх зэрээр дурьдажээ. Мөн "БНМАУ-ын түүх (1966 он) хамтын бүтээлд Дөчин дөрвөн хоёрын төр нэгдсэн <sup>40</sup> гэж бичсэн ч хожим төдий л хэрэглэхгүй байжээ. Түүхч М.Санждорж гуай нэгэн сэдэвт бүтээлдээ "чингэхлээр тухайн үеийн монгол улс нь оноосон нэргүй улс байсан бус түүхийн хайлласан "Дөчин дөрвөн хоёрын Монгол улс" хэмээн нэрлэхэд болохгүй зүйлгүй санагдана. Ямар боловч монголын феодалын бутралын үе", "улс төрийн бутралын үе" мэтээр монголыг тусгаар төр улс хэмээхийг орхигдуулсан тийм нэрнээс илүү оновчтой санагдана<sup>41</sup> гэж улсын нэрийн талаар өөрийн саналаа дэвшүүлж байжээ. Энэ саналыг үндэслэн шинээр хэвлэгдсэн "Монгол Улсын түүх таван боть зохиолд" Дөчин дөрвөн хоёр "Монгол улс" гэсэн нэртэй адилтган хэрэглэсэн нь харагдаж байна.<sup>42</sup> Энэ нэрийн талаар түүхч Алтан-Оргил: Мин, Чин улсын хаадаас Монгол Ойрад хоёрын хооронд зөрчил үүсгэж, салангти тусгаар байлгаж ноёрхох гэсэн зорилгодоо хүрэхийн төлөө элдэв заль мэх гарган зориуд Монгол Ойрад хоёрыг ингэж нэрлэдэг байсантай холбоотой<sup>43</sup> үүсмэл нэр болохыг тэмдэглэжээ. Үнэхээр энэ нэрийдэл нь түүх сурвалжийн мэдээг үндэслэвэл 1440-өөд оноос 1450-аад оны дунд үе хүртэл 20 гаруйхан жилийн түүхэн үйл явдалтай холбогдох тул тухайн үеийн монголын түүхийн бүхийл үеийг илтгэн харуулах нэр болж хараахан чадахгүй ч гэсэн нэг талаар монголчуудын сүр хүч нэгдмэл байдлыг илэрхийлсэн уламжлалтай холбоотой бэлгэдлийн нэр юм. Мөн баруун, зүүн Монголын тус тус бие даасан байдал эдүгээгийн ойлголтоор холбооны (федерацийн) улсын дүр төрхийг санагдуулж . . ."<sup>44</sup> байгаатай холбон тайлбарлахад энэ нэрийдэл бас ч оновчтой санагдана.

XVII-XIX зууны монголчуудын сурвалж бичигт дээр дурьдсан олон нэрнээс гадна XIV-XVII зууны улсын нэрийг "Монгол улс" гэж тэмдэглэсэн нь бүр ч олонтоо. Хүчирхэгжин мандсан, супран доройтсон эвсэн нэгдсэн энэ үеийг түүхийн бүхий л түүхийг егүүлэхдээ түүхч Саган Сэцэн (т.284, 285, 292, 306) Гүн Гомбожав (т.10), Ломи (т.227, 240, 244, 245-277), Жамбадорж (т.444, 445), Рашпунцаг (т. 338, 343, 345, 341) бүгд л "Монгол улс" хэмээн нэрлэжээ. Иймээс, манай Монгол Улсын эртнээс улбаалсан эцэг, эхийн нэр мэт дотно, ямар нэг гоёж чимсэн, аль нэг цагийн аяст зохицсон элдэв тодотгол үггүй, даруу мөртлөө эрхэмсэг хүндтэй, цаг цагийн шуурганд орхигдон мартагдаагүй дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн нэр бол Монгол улс хэмээх нэр билээ.

<sup>38</sup> Саган Сэцэн ... т. 304, 316, 322, 329, 330

<sup>39</sup> "Ойрад Монголын түүхэнд холбогдох сурвалж бичгүүд-3" УБ., 2002 т. 207-208

<sup>40</sup> БНМАУ-ын түүх., 1966 т. 422

<sup>41</sup> Санждорж.М "Монголын төрийн түүхээс" XIII-XIX зуун УБ., 1998 т. 16., 79

<sup>42</sup> "Монгол Улсын түүх" (гутгаар боть), 2004 т.

<sup>43</sup> Алтан-Оргил дээр дурьдсан зохиол

<sup>44</sup> Санждорж.М ... УБ., 1998 т. 83

**Abstract:**

The conventional designation of the Mongolian state during the 14-17<sup>th</sup> centuries was referred to in various different ways, such as *Mongol Uls* ("Mongolia"), *Yuanii Khoichis* ("Remnant of the Yuan Empire"), *Ming Ulsyn Uyeiin Mongolchuud* ("The Mongols during the Ming Empire"), *Umarad Yuan* ("The Northern Yuan Empire"), *Bei-Lu* ("The Northern Frontier"), *Dochin Tumen Mongol Uls* ("The Mongolian State of Forty Leagues"), *Dochin Dorvon Khojoryn Mongol Uls* ("The State of the Forty and Four Leagues") etc. Among those, the most verifiable name to designate the national state during that period is *Mongol Uls* (Mongolia).

**Ном зүй**

1. БНМАУ-ын түүх. УБ., 1966
2. Гомбожав "Чингис эзний алтан ургийн түүх Гангийн урсгал нээрт түүх оршибай" УБ., 1992
3. Дай Хуни, Буян "Умард Юаний түүх" Хайлаар. 1991
4. Далай, Ч "Монголын түүх" (гутгаар дэвтэр) УБ., 1992
5. Даарайжав "Мин Улсын үеийн.govийн өмнөх монголын түүхийн судлал" Бээжин. 1997
6. Дармагүүш "Есөн зүйл бүлэгт алтан урагтны тод түүх, алтан ястны сэтгэлийн цэнгэл буюу алтан хүрдэн мянган хигээст бичиг" Хөх хот. 1987
7. Жамбадорж "Болор толь" Хөх хот. 1994
8. Ломи "Монгол боржигид овгийн түүх" Хөх хот. 1989
9. Лувсандаанзан "Алтан товч" УБ., 1970
10. Монгол Улсын түүх (гутгаар боть) УБ., 2003
- 11) Пунсаг. А "Монголын түүхэнд холбогдох хятад сурвалжуудын мэдээ" (ШУА. Түүхийн хүрээлэн гар бичмэл)
12. Раашпунцаг "Дай Юань Улсын болор эрхи" Хөх хот. 2000
13. Саган Сэцэн "Эрдэнийн товч" Хөх хот. 1984
14. Санждорж. М "Монголын төрийн түүхээс" (XIII-XIV зуун) УБ., 1991